

**ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН 2023 ОНЫ
11 ДҮГЭЭР САРЫН ЦАГ ҮЕИЙН МЭДЭЭ**

НЭГ. УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ХҮРЭЭНД

Аймгийн Удирдах ажилтны шуурхай зөвлөгөөнийг 2 удаа зохион байгуулж, аймгийн Засаг даргаас 13 үүрэг даалгавар өгч, хэрэгжилтийг тооцон ажилласан.

Онцой байдлын газраас Цаг агаарын нөхцөл байдал хүндэрсэнтэй холбогдуулан Аймгийн онцгой комиссоос аймгийн Гамшгаас хамгаалах алба мэргэжлийн анги, Сүмбэр, Баянтал, Шивээговь сумын ерөнхий зориулалтын мэргэжлийн ангийн хүн хүч, техник, тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл тодотгон томилгоожуулж хүн нэг бүрийн хээрийн үүргэвчийн бэлтгэл бэлэн байдлыг шалгаж, зудын хариу арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулан баталгаажуулан ажилласан.

Онцгой байдлын газар нь 2023 оны 10 дугаар сарын 25-наас 11 дүгээр сарын 23-ны өдрийн хооронд аймгийн хэмжээнд гамшгийн 7 дуудлагатай байлаа.

Онцгой байдлын ерөнхий газрын даргын удирдамжийн хүрээнд аймгийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулдаг 11 байгууллагад “Боловсролын байгууллагын барилга байгууламжид”-д гүйцэтгэлийн хяналт шалгалтыг Төрийн хяналт шалгалтын тухай, гамшгаас хамгаалах тухай, галын аюулгүй байдлын тухай хууль, холбогдох норм, стандарт, дүрэм журмыг мөрдлөг болгон зохион байгуулан ажилласан.

Шивээговь сумын 2 дугаар багийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулдаг Шивээ-Овоо ХК-д гамшиг осол, гал түймрээс урьдчилан сэргийлэх үзлэг шалгалтыг зохион байгуулж, зөвлөн туслах үйлчилгээг үзүүлсэн.

Терроризмтой тэмцэх салбар зөвлөлийн төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу Тагнуулын хэлтэстэй хамтран тэсрэх бодисын агуулах, үйлдвэрийн зориулалттай 2 аж ахуй нэгж байгууллагад хяналт шалгалт зохион байгуулж ажилласан.

Онцгой байдлын ерөнхий газрын даргын 2021 оны А/154 дүгээр тушаалаар батлагдсан “Галын аюулгүй байдлын дүгнэлт гаргах журам”-ын 1 дүгээр хавсралтыг үндэслэн Emongolia цахим сайтаар 3 иргэн, аж ахуй нэгж байгууллагын гаргасан хүсэлтийн дагуу галын аюулгүй байдлыг шалган илэрсэн зөрчил дутагдалд мэргэжил арга зүйн зөвлөмж өгч, ажлын байрны галын аюулгүй байдлын дүгнэлт 3-ыг олгож 75.000 төгрөгийг тэмдэгтийн хураамжийн хуулийн дагуу орон нутгийн орлогод төвлөрүүлсэн байна.

Улсын Онцгой комиссын 01, Онцгой байдлын ерөнхий газрын даргын 02 албан даалгавар, Аймгийн Засаг даргын баталсан “Намрын нэгдсэн эргүүл шалгалт зохион байгуулах тухай” А/290 дүгээр захирамжийн хүрээнд 2023 оны 10 дугаар сарын 23-ны өдөр Сүмбэр сумын ЗДТГ, Байгаль орчин, аялал жуулчлалын газартай хамтран тус сумын 5, 6 дугаар багийн нутаг дэвсгэрт хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх үзлэг шалгалтыг зохион байгуулж ажилласан.

Говьсүмбэр аймагт 2023 онд зохион байгуулах Гамшгаас хамгаалах ангиллын сургалт нэгдсэн төлөвлөгөөний хүрээнд 18 удаа нийт 198 ажилтан, албан хаагч, сурагчид, иргэдэд газар хөдлөлт, Гамшгаас хамгаалах төлөвлөгөө боловсруулах аргачлал, гамшгийн үед хэрхэн ажиллах тухай анхан шатны ойлголт, галын аюулгүй байдлын тухай ойлголт, гал унтраах дадлага сургууль, “what3words” программын ашиглах талаар 18 цагийн сургалт зохион байгуулан ажилласан.

Онцгой байдлын ерөнхий газар болон Цаг уур орчин шинжилгээний газраас ирүүлсэн цаг агаарын сэрэмжлүүлэг мэдээ 25, Онцгой байдлын газрын үйл ажиллагааны чиглэлээр 12 удаагийн мэдээг Онцгой байдлын газрын болон “go.nema.gov.mn” сайтад байршуулж “Чойрын зар”, “Боржигин нутаг минь”, “Шивээговь нэгдсэн зарын групп”, “Говьсүмбэр аймаг” “govisumber.gov.mn”, “Govisumbernews.mn” гэсэн хаягуудад шейрлэж иргэдэд хүргэн

ажилласан. “Go.nema.gov.mn” сайтад 2023 оны 11 дүгээр сарын 23-ны өдрийн байдлаар 77934 хандалт хийгдсэн байна.

Цаг агаарын хүдрэлтэй байдал сэрэмжлүүлэг багц мессежийг 2 удаагийн тавтамжтай давхардсан тоогоор 1604 малчин иргэдэд хүргэсэн.

Говьсүмбэр аймгийн Сүмбэр сумын 3 дугаар багийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулдаг “Холбооны газар”-т гамшгийн эрсдэлийн үнэлгээ хийх аргачлал, үнэлгээний ач холбогдол сэдвээр сургалт орж Гамшгийн эрсдэлийн ерөнхий үнэлгээг хийлгэсэн.

Аймгийн хэмжээнд Зудын эрсдэлийн ерөнхий үнэлгээ хийх ажлын хэсгийг аймгийн Засаг даргын 2023 оны 11 дүгээр сарын 10-ны өдрийн А/324 дүгээр захирамжаар байгуулан 11 дүгээр сарын 13-ны өдөр тус ажлын хэсэг аймгийн хэмжээний Зудын эрсдэлийн үнэлгээг хийж зөвлөмж гарган аймгийн Онцгой комисст танилцуулан ажилласан. Тус үнэлгээгээр аймгийн хэмжээнд ДУНД үнэлгээтэй гарсан байна.

Монгол Улсын Шадар сайдын ивээл дор Шадар сайдын ажлын алба, Онцгой байдлын ерөнхий газар, Стандарт хэмжил зүйн газар, “Мандал санхүүгийн нэгдэл” ХХК-тай хамтран зохион байгуулсан 14 дэх удаагийн “Эрсдэлийн үндэсний форум”-д 70 гаруй хүний бүрэлдэхүүнтэй оролцож, орон нутагтаа зохион байгуулсан.Тус форум нь улс оронд тулгарч болзошгүй нийгэм, эдийн засаг, гамшгийн эрсдэлүүд, тэдгээрээс урьдчилан сэргийлэх арга замын талаар хэлэлцэж бодит шийдлийг эрэлхийлж, төр, хувийн хэвшил, иргэний зүгээс эрсдэлийг удирдахад чиглэгдсэн.

Онцгой байдлын газрын даргын 2023 оны 10 дугаар сарын 27-ны өдрийн А/64 дүгээр тушаал, 2023 оны сургуулийн жилд танхимаар судалсан онолын мэдлэгийг бататгах, газар орон дээр болон бодит байдалд тулгуурлан дадлага олгох, бэлтгэл бэлэн байдлыг хангах, алба хаагчдын гүний усанд шумбах, эрэн хайх аврах ажиллагааны ур чадварыг сайжруулах, Хаялага нуурын эрсдэлтэй гүнийг тодорхойлох зорилгоор 2023 оны 10 дугаар сарын 30-ны өдөр Шивээговь сумын 1-р багийн нутаг дэвсгэрт байрлах Хаялга нуурт “Экстрем монголиа” аялал жуулчлалын компаний гүний усны шумбалтын багш, дасгалжуулагч Б.Пүрэвдаваа, Отгондэмбэрэл нар удирдан зохион байгуулсан.

Онцгой байдлын ерөнхий газрын дэд дарга, хурандаа Д.Намсрайгаар ахлуулсан ажлын хэсэг 11 сард Онцгой байдлын газрын 2023 оны жилийн эцсийн ажил дүгнэх хяналт шалгалт зохион байгуулан ажиллаж байна. Ажлын хэсгийн бүрэлдэхүүн Онцгой байдлын ерөнхий газрын даргын 2022 оны 04 дүгээр сарын 06-ны А/88 тушаалын дагуу Онцгой байдлын байгууллагын үйл ажиллагаанд хэрэгжүүлэх, дүрэм, журам стандарт байгууллагын бодлого, зорилт, гүйцэтгэлийн төлөвлөгөө, төсөв, төслийн хэрэгжилтийн явц, үр дүн, удирдлага, зохион байгуулалт, үйл ажиллагаанд үнэлгээ, дүгнэлт хийж ажилласан.

Аймгийн онцгой комиссын 2023 оны 11 дүгээр сарын 08-ны өдөр 10 цагт Онцгой байдлын газрын хурлын танхимд 17 буюу 62,9% ирцтэй хуралдсан. Цаг агаарын нөхцөл байдал болон Төв суурин газар, Хөдөө аж ахуйн салбарын өвөлжилтийн бэлэн байдлын талаар мэдээлэл, малын гоц халдварт цэцэг болон мялзан өвчнөөр өвчилж эдгэрсэн малд хяналт тавьж ажилласан талаар болон мал эмнэлгийн технологит ажлын талаар мэдээлэл гэсэн 5 асуудлын талаар хэлэлцсэн.

ХОЁР. ЭДИЙН ЗАСАГ, ТӨСӨВ, САНХҮҮГИЙН БОДЛОГЫН ХҮРЭЭНД

2023 оны 11 дүгээр сарын нийт татварын орлогын төлөвлөгөө 10 905,1 мянган төгрөг гүйцэтгэлээр 10 905,1 мянган төгрөг буюу 100 %, үүнээс Улсын төсвийн орлогын төлөвлөгөө 1 574,0 мянган төгрөг гүйцэтгэлээр 1 574,0 мянган төгрөг буюу 100% гүйцэтгэлтэй байна. Сумын төсвийн орлогын төлөвлөгөө 6 694,1 мянган төгрөг төвлөрүүлэхээс 6 694,1 мянган төгрөг буюу 100%, аймгийн төсвийн орлогын төлөвлөгөө 2 637,0 мянган төгрөг төвлөрүүлэхээс 2 637,0 мянган төгрөг буюу 100% гүйцэтгэлтэй байна.

Татвар төлөгчдийн бүртгэлийг сайжруулж, татварын бааз суурийг нэмэгдүүлэх хүрээнд 2023 оны 01 дүгээр сарын 01-ний өдрийн байдлаар 698 хуулийн этгээд бүртгэлтэй байсан бол 2023 оны 10 дугаар сарын 24-ний байдлаар 752 болж өссөн. Татвар төлөгчдийн хариуцлагын хэлбэрээр харуулбал: Үүнд: ХК-1, ХХК-406, ББН -5, ЗБН -11, Хоршоо -40, ХЗХоршоо- 1, ОНӨҮГ-6, Салбар-66, төсөвт болон төрийн бус байгууллага, сан ОНБ – 216 байна.

Статистикийн чиглэлээр:

Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний үнийн ХАА-3 мэдээг хуваарийн дагуу сумаас хугацаанд нь бүрэн авч сар бүр Үндэсний Статистикийн хороонд дамжуулсан. Аж үйлдвэрийн салбарын АҮ-1, Зочид буудлын үйл ажиллагааны ЗБ-1, Зоогийн газрын үйл ажиллагааны ЗГ-1, АҮСҮ-1 мэдээнүүдийг Аж ахуйн нэгж байгууллагуудаас хугацаанд нь бүрэн авч Үндэсний Статистикийн хороонд дамжуулсан. Барилга байгууламж объектын ББО-1 мэдээг хугацаанд нь Үндэсний Статистикийн хороонд дамжуулсан. Тодруулгуудыг хийж гүйцэтгэсэн. Аймгийн 2023 оны 10 сарын Нийгэм эдийн засгийн танилцуулга болон хэвлэлийн бага хурлыг бэлтгэн нийтэлсэн. Хэрэглээний бараа үйлчилгээний үнийн сарын Үнэ-21 мэдээг 1 удаа, 7 хоногийн үнийн Үнэ-2 мэдээг 4 удаа дамжуулсан. Ажиллах хүчний судалгаа, Ногоон ажлын байрны судалгааны 30 өрхөөр судалгаанд явсан. Судалгааны тодруулгуудыг тухай бүр тодруулан Үндэсний Статистикийн хороонд дамжуулсан.

Нийгмийн үзүүлэлтийн түүвэр судалгааны багийн судлаачдыг байрлуулах багууд руу холбох, айлуудын байршлыг тодруулах зэрэгт хамтран ажилласан. 5 жил тутам явагддаг уг судалгааны 8 хүн нийт 215 өрхөөс 2023 оны 10 дугаар сарын 26-аас 2023 оны 11 дүгээр сарын 20-ны хооронд Нийгмийн үзүүлэлтийн түүвэр судалгааг авсан. 3 жил тутам хийгддэг Малын ашиг шим, нэмүү өртгийн судалгааны программд шивэлтийн ажил 70-80 хувьтай үргэлжилж байна.

Санхүүгийн хяналт аудитын алба:

Санхүүгийн хяналт шалгалтыг төлөвлөгөөт 14, төлөвлөгөөт бус 9 байгууллагад нийт 23 байгууллагад хийж 4.168.320,6 мянган төгрөгийн зөрчил илрүүлснээс 12.016,8 мянган төгрөгийг улсын төсвийн орлого болгуулахаар, 28.060,8 мянган төгрөгийг орон нутгийн орлого болгуулахаар, 7.100,2 мянган төгрөгийг хувь хүнд нь буцаан олгуулахаар нийт 47.177,8 мянган төгрөгийн улсын ахлах байцаагчийн нөхөн төлбөрийн акт тогтоосон. Актын барагдуулалтын үр дүн 58 хувьтай байна.

Шилэн дансны тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2-т заасны дагуу аймгийн төсөвт, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар нийт 43 байгууллагын шилэн дансны мэдээллийг цахим хуудсанд үнэн зөв болон цаг хугацаандаа оруулж байгаа эсэхэд хяналт тавьж ажилладаг. 10 дугаар сарын шилэн дансны мэдээ оруулалтын байдалд хяналт шалгалтаар хуулийн хэрэгжилт 97,9 хувьтай байгаа бөгөөд өмнөх сараас 4.9 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

ГУРАВ. ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН БОДЛОГЫН ХҮРЭЭНД

Эрх зүйн сургалт, сурталчилгааны ажлын хүрээнд:

Аймгийн Засаг даргын Тамгын газрын фейсбүүк хуудас, Хууль Эрх зүйн хэлтсийн фейсбүүк хуудсаар дамжуулан “Худалдах худалдан авах гэрээ, Цахим залилангаас урьдчилан сэргийлэх” тухай мэдээлэл хүргэн ажиллалаа. /хандалтын тоо-Давхардсан тоогоор 119/

Архивын тасаг:

Архивын баримтыг цахим хэлбэрт шилжүүлэх ажлын хүрээнд 2 хөмрөгийн 14 хадгаламжийн нэгжийн 2022 хуудас, 125 заалт, 499 хүний нэр, 125 байгууллагын нэр, 375 газар зүйн нэр, 1083 потшоф, 2022 скайнер, 876 холболт хийж ажилласан. 2023 оны 11 дүгээр сард 16 иргэнд лавлагаа гаргаж үйлчилгээ үзүүлсэн.

УЛСЫН БҮРТГЭЛИЙН ХЭЛТЭС

Иргэний бүртгэлийн чиглэлээр:

- Шинээр гадаад паспорт захиалсан- 250
- Иргэний үнэмлэх шинээр олгосон- 65
- Төрснөө бүртгүүлсэн хүүхдийн тоо— 25
- Гэрлэлт бүртгүүлсэн тоо - 2
- Гэрлэлт цуцлуулснаа бүртгүүлсэн тоо -2
- Эцэг тогтоолтын бүртгэлийн тоо - 2
- Нас барсныг бүртгүүлсэн тоо - 9
- Өөр аймаг, хотоос шилжиж ирсэн нийт иргэн - 56
- Аймаг дотор шилжсэн иргэдийн тоо - 22
- Тоон гарын үсэг олголт - 114

Нийт - 547

Эд хөрөнгийн бүртгэлийн чиглэлээр:

- Үл хөдлөх хөрөнгийг анхны удаа баталгаажуулах бүртгэл - 5
- Гэрээний бүртгэл - 50
- Барьцааны гэрээний бүртгэл - 127
- Эд хөрөнгөд орсон өөрчлөлт, залруулга - 4

Нийт - 186

Хуулийн этгээдийн бүртгэлийн чиглэлээр:

- Шинээр байгуулагдсан хуулийн этгээдийн бүртгэл - 5
- Хуулийн этгээдийн бүртгэлийн өөрчлөлт -7
- Татан буугдсан хуулийн этгээдийн бүртгэл -

Нийт - 12

Архивын чиглэлээр:

- Төрийн байгууллагад гаргасан лавлагаа, хуулбар - 31
- Хуулийн этгээдэд гаргасан лавлагаа, хуулбар - 0
- Иргэнд гаргасан лавлагаа, хуулбар - 522

Нийт- 553

Төрийн үйлчилгээг нийт 1298 иргэнд хүргэсэн байна.

Шүүхийн шинжилгээний хүрээнд

Хэргийн газрын үзлэг-12, үүнээс хүний амь нас хохирсон-3, зам тээврийн осол-2, бусад-7, Хэргийн газрын үзлэгийн болон эд мөрийн баримт-13, эрэн сурвалжлах, танин олуулах ажиллагаа хэргийн газрын давтан үзлэг, нэгжлэг, цогцос задлан шинжлэх ажиллагааны 304 кадр гэрэл зургийг боловсруулан холбогдох материалд хавсаргасан байна. Хүний биед гэмтлийн зэрэг тогтоох үзлэг 16 үүнээс Хүнд-1, Хүндэвтэр-1, хөнгөн-8, гэмтлийн зэрэгт хамаарахгүй-4, гэмтэл тогтоогдоогүй-2. Цогцост хийсэн шинжилгээний тоо-3

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар

2023-2024 онд алба хаагчдыг чадавхжуулах сургалтын хөтөлбөрийн хүрээнд Ангийн даргын 2023 оны 10 дугаар сарын 25-ны өдрийн А/44 дүгээр тушаалаар сургалтын төлөвлөгөөг үндсэн 5 чиглэлийн хүрээнд 240 цагийн сургалтын цаг сэдвийг батлагдсан төлөвлөгөөний дагуу сургалтуудыг аймгийн Насан туршийн боловсролын төв, Боржигон өв музей, Хүүхэд, гэр бүл, залуучуудын газартай хамтран 14 хоног тутам зохион байгуулж байна.

Өнөөдрийн байдлаар нийт 10 цагийн сургалтыг зохион байгуулсан. Сургалт 4.1 хувийн биелэлтэй.

2023 оны 11 дүгээр сарын 23-ны өдөр “Энх билиг” эмнэлэгтэй хамтран нийт 45 алба хаагчдыг урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулсан.

Тайлант хугацаанд нийт 19 хоригдолтой “Нийгмийн ажлын үйлчилгээний гэрээ” байгуулж, “Хорих ял эдлэх үеийн жишиг хөтөлбөр”-ийн дагуу нийгэмшүүлэх ажлын төлөвлөгөө боловсруулан ажилласан. 2023 оны 11 дүгээр сарын байдлаар 102 хоригдол ар гэрийн хүсэлтийн дагуу цахим уулзалтад хамрагдсан

Хоригдлуудад тулгамдаад буй асуудлуудад тухай бүр эрх зүйн зөвлөгөө өгч, яриа таниулга хийн нийт 160 хоригдлын гаргасан хүсэлтийг хүлээн авч ангийн удирдлагад танилцуулан холбогдох албан тушаалтан, байгууллагад зохих журмын дагуу явуулж зөрчилгүй шийдвэрлэж ажилласан.

Тайлант хугацаанд суллахад бэлтгэх хөтөлбөрийн хүрээнд Говьсүмбэр аймгийн Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газартай хамтран ажиллах төлөвлөгөөний хүрээнд 2 цагийн сургалт зохион байгуулсан. Суллагдах дөхсөн хоригдлуудыг холбогдох сургалтад хамруулж, суллагдсаны дараа 24 хоригдлыг “малчин”, “хувийн компанид туслах ажилтан” гэх зэрэг ажлын байранд зуучилсан.

Гэм хорын төлбөртэй хоригдлуудаас цалинтай ажлын байраар 3 хоригдол хөдөлмөрт хамрагдаж байгаа бөгөөд ангийн байрлалд үйл ажиллагаа явуулж байгаа “ОСО КОНСТРАКШ” ХХК-ний хөнгөн блок үйлдвэрт ажиллаж байна. Тус 3 хоригдлын хөдөлмөрийн хөлснөөс 1,138,500 төгрөгийг хохирол төлбөрт шилжүүлэхээр хорих ангийн дансанд байрлуулаад байна.

Хоригдлын чөлөөт цагийг үр бүтээлтэй өнгөрүүлэх, авъяас чадварыг нээн хөгжүүлэх зорилгоор давхардсан тоогоор гитар хөгжмийн дугуйланд 6 хоригдол, бясалгалын сургалтад 35 хоригдол, шагайн харваан дугуйланд 17 хоригдол, шатрын дугуйланд 23 хоригдол, даамны дугуйланд 21 хоригдол, морин хуурын дугуйланд 6 хоригдол, ширээний теннисний дугуйланд 30 хоригдол, Архичид аминчлахуй сургалтад 17 хоригдол, монгол бичгийн дугуйланд 13 хоригдол, нийт 9 төрлийн сургалт, дугуйлангийн үйл ажиллагааг идэвхжүүлэн 168 хоригдол хамрагдаж байна.

Хоригдлын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх, хөдөлмөрийн дадал олгох чиглэлээр хорих ангид өнөөдрийн байдлаар 212 хоригдол ял эдэлж байгаагаас 153 хоригдлыг хөдөлмөрт хуваарилсан нь нийт 72,8 хувийг ажлын байраар хангаж хөдөлмөрт хамруулаад байна. Тус хоригдлуудаас хорих ангийн үйлдвэрийн хэсэгт нийт 48 хоригдлыг хөдөлмөрийн дадал олгож мужаан цех, гагнуур, даалин оёх, гөлөм оёх, суран эдлэх хийх, оёдол хийх, гар урлал хийх зэрэг төрлүүдээр хөдөлмөрт хамруулж хүмүүжигч нарын үйлдвэрлэж урласан бүтээлийг арвижуулах, чанаржуулах, олон нийтэд таниулах зорилгоор үзэсгэлэнгийн өрөөг тохижуулан бүтээлүүдийг байршуулсан.

2023 оны 11 дүгээр сарын байдлаар 385 гүйцэтгэх баримт бичгийн 24663676.3 төгрөг, 236 гүйцэтгэх баримт бичгийн 7881748.2 төгрөгийг бодитой биелүүлж 149 гүйцэтгэх баримт бичгийн 16781927.9 төгрөгийн үлдэгдэлтэй байна. 2023 оны 11 дүгээр сарын гүйцэтгэх хуудасны бодит биелэлт 61.3 хувьтай ажиллаж байна.

Бодит биелэлт гүйцэтгэх хуудасны тоогоор 61.3 хувьтай байгаа нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад гүйцэтгэх хуудасны бодит биелэлт 9.2 хувиар өссөн, улсын дунджаас 8.9 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

Цагдаагийн хэлтэс

Цагдаагийн хэлтэс нь Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журам /код 202/ “Гэмт хэрэг зөрчлийн талаарх гомдол, мэдээллийг хүлээн авах” журамд заасны дагуу 2023 оны 10 дугаар сарын 25-ны 05 цагаас 2023 оны 11 дүгээр сарын 25-ны хооронд иргэд, аж ахуйн нэгж байгууллагаас нийт 138 дуудлага мэдээллийг хүлээн авч шалгаснаас гэмт хэргийн 9, зөрчлийн 114 мэдээлэл байна.

Тайлангийн хугацаанд зөрчил үйлдсэн 2631 иргэнийг эрх бүхий албан тушаалтнаас болон шүүхээс 79,875,000 төгрөгөөр торгож, согтуугаар зөрчил гаргасан 29 хүнийг эрүүлжүүлж, 21 хүнийг шүүхээр баривчлуулан, согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодсон 26 жолоочийн тээврийн хэрэгсэл жолоодох эрхийг хассан.

Хариуцсан нутаг дэвсгэрийн эрүү, хэв журмын нөхцөл байдалд дүн шинжилгээ хийж, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлэх зорилгоор давхардсан тоогоор

худалдаа, үйлчилгээний үйл ажиллагаа эрхэлдэг 51 цэгийн үйлчилгээний цагийн хуваарьт өдөр тутам хяналт шалгалт хийж, зөвлөгөө өгсөн.

Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр гудамж талбай, олон нийтийн газарт гэмт хэрэг, зөрчил үйлдэгдэхээс урьдчилан сэргийлэх, илрүүлэх, таслан зогсоох чиглэлээр Сүмбэр сумын нутаг дэвсгэрт найрамдал хотхон, дэнж, төмөр зам, аяганы хонхор, Баянтал сум, Шивээговь сумдын нутаг дэвсгэрт эргүүлийг тасралтгүй зохион байгуулж давхардсан тоогоор 270 алба хаагч 2160 цагийн эргүүлийн үүрэг гүйцэтгэж байгууллага, аж ахуйн нэгжийн халдвар хамгааллын дэглэмийг сахиулж, заавар зөвлөгөө өгч ажилласан.

Энэ оны 11 сард гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг цахим хэлбэрээр олон нийтэд хүргэх, хууль сурталчилах, ухуулах, цаг үеийн болон нөхцөл байдлын талаарх мэдээ мэдээллийг түгээх ажлыг тасралтгүй зохион байгуулж, төв, орон нутгийн холбогдох байгууллагаас цахим орчинд нийтлэсэн гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх санамж, анхааруулга, зөвлөмж 15, видео шторк 20, бусад 11 нийт 46 мэдээллийг "Говьсүмбэр аймгийн цагдаагийн хэлтэс" пэйж хуудсанд байршуулж, иргэд, олон нийтэд түгээж, цагдаагийн байгууллагын үйл ажиллагааг сурталчилав.

Цахим орчинд үйлдэгдэж буй хүүхдийн эсрэг гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, хамгаалах, өсөлтийг бууруулах, иргэдийн эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх, мэдээллийн технологийн зохистой хэрэглээг бий болгох зорилгоор 2023 оны 09 дүгээр сарын 15-ны өдрөөс 2023 оны 12 дугаар сарын 25-ны өдөр хүртэл "Private ш дээ- Нууцалья" нөлөөллийн аян явагдаж байна.

Цагдаагийн ерөнхий газраас зохион байгуулж буй "Илрүүлэлт-Оргодол-Шийдвэрлэлт-2023, "Хүчирхийлэлгүй гэр бүл- хүчирхийлэлгүй ирээдүй" хамтарсан аян, "Зэвсэг- 2023" нэгдсэн арга хэмжээ, "Мал мах-2023" хэсэгчилсэн арга хэмжээнүүдийн постер, видео бичлэгүүдийг байгууллагын фейж хуудсанд байршуулан олон нийтэд түгээж ажилласан.

Шивээговь сумын ерөнхий боловсролын 3 дугаар сургуулийн ахлах ангийн сурагчдад "Согтууруулах ундааны хор уршиг", " замын хөдөлгөөний аюулгүй байдал" сэдвээр, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Хууль зүй дотоод хэргийн сайдын 2022 оны А/167, А/223 дугаар хамтарсан тушаалаар баталсан "Хоригдлыг суллахад бэлтгэх хөтөлбөр"-ийг хэрэгжүүлэх төлөвлөгөөний дагуу Шүүхийн шийдвэр гүйцэтгэх 0425-р ангийн хүмүүжигч нарт, Татварын хэлтэст "Гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх" тухай, Зөрчлийн тухай хууль болон мансууруулах эм, сэтгэцэд нөлөөлөх бодисын хууль бус эргэлттэй тэмцэх урьдчилан сэргийлэх сэдвээр сургалт зохион байгуулан ажилласан.

Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг, Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газар, Боловсролын ерөнхий газартай хамтран "Хамтдаа шалгая, хамгаалъя" арга хэмжээний хүрээнд цагдаагийн хэлтэс нь гадна, дотно орчны үнэлгээ хийсэн бөгөөд хүүхдийн эрүүл, аюулгүй амьдрах орчин нөхцөл 100 хувь хангагдаж байна

Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах "Хяналт шалгалт" 11 дүгээр сарын 8-аас 11 дүгээр сарын 30-ыг хүртэл, "Тээврийн хэрэгслийн бүрэн бүтэн байдал" 11 дүгээр сарын 10-наас 12 дугаар сарын 01-ний өдөр хүртэл "Уусан бол бүү жолоод" арга хэмжээнүүдийг зохион байгуулан ажиллаж байна.

ДӨРӨВ. НИЙГМИЙН БОДЛОГЫН ХҮРЭЭНД

Боловсролын чиглэлээр:

Бага насны хүүхдийн хөгжлийг дэмжих төв Төрийн бус байгууллагатай хамтран "Бага насны хүүхдийн цогц хөгжлийн сургалт"-ыг суургуулийн өмнөх боловсролын хүрээнд "Бага насны хүүхдийн тархины болон цогц хөгжил төлөвшил, эрүүл мэнд, асаргаа халамж, хүүхэд хамгаалал, зохистой хоол тэжээл, насны онцлогийг нь мэдүүлж эцэг эх, асран хамгаалагчийн үүрэг оролцоог нэмэгдүүлэх" чиглэлээр 1000 эцэг эхэд сургалт зохион байгуулсан. Сургалтад Сургуулийн өмнөх боловсролын 1,2,3,4,5,6 цэцэрлэг, Боловсрол, шинжлэх ухааны газартай хамтран ажилласан.

Ерөнхий боловсролын сургалтын үйл ажиллагаанд Pearson, Eduten цахим системийг нэвтрүүлэн хэрэгжүүлж буй гарааны нөхцөл байдалтай танилцах ажлын хүрээнд 5 сургууль дээр сургагч багш нар, Боловсрол, шинжлэх ухааны дарга, мэргэжилтнүүд хамтран ажилласан.

Зүүн бүсийн Физикийн XXIV олимпиад Хэнтий аймгийн Дадал сумнд 2023 оны 11 дүгээр сарын 03-ны өдрөөс 05-ны өдрүүдэд амжилттай зохион байгуулагдсан. Тус олимпиадад Говьсүмбэр аймгийг төлөөлөн Ерөнхий боловсролын 1 ба 5 дугаар сургуулийн баг амжилттай оролцоноос багшийн төрөлд 5 дугаар сургуулийн физикийн багш Ж.Мөнх-Оргил хүрэл, түүний бэлдсэн 8-р анги сурагч алт, 9-р ангийн сурагч хүрэл, 10-р ангийн сурагч мөнгө, хүрэл медаль хүртсэн амжилт гаргасан.

3,4-р ангийн Математикийн хичээл дээр Eduten цахим системийг туршин хэрэгжүүлж буй дэмжигч багш нарын нийт 8 цагийн хичээлд ажиглалт хийж, 5-12-р ангийн Англи хэлний хичээлд, Pearson цахим платформын сургалтанд нэвтрүүлж буй 6 цагийн хичээлд ажиглалт, сургалтын орчины шинжилгээ хийсэн. Ажиглалтын тайлан, материалыг Боловсролын ерөнхий газарт илгээсэн.

Боловсролын үнэлгээний төвтэй хамтран 3,4-р ангийн Математикийн хичээлээр Eduten цахим системийг ашиглах гарааны үнэлгээг зохион байгуулсан. Үнэлгээнд 5 сургуулийн 15 бүлгийн 799 суралцагч хамрагдаж, 3-р анги 47,9 хувь, 4-р анги 38,6 хувьтай оношлогдсон. Үнэлгээний датаг Боловсролын үнэлгээний төвд илгээсэн.

Үнэлгээний төрөл хэлбэр, үнэлгээний арга зүй сэдэвт сургалтыг Политехникийн коллежийн ерөнхий эрдмийн багш нар, Ерөнхий боловсролын шинээр ажилд орсон нийт 26 багш нарын хүрээнд зохион байгууллаа. Сургалтыг БШУГ-ын мэргэжилтэн, үнэлгээний шинжээч багш нар хамтран зохион байгуулсан. Сургалтын үр дүнд үнэлгээний журмын хэрэгжилт цаашид анхаарах асуудал, үр дүнгийн үнэлгээний Блюпринт боловсруулах арга аргачлалд суралцлаа.

Дэлхийн банкны санхүүжилтээр, L5-94 төсөл Сургуулийн менежментийг сайжруулах, сургагч багш бэлтгэх сургалтанд ахлах мэргэжилтэн, 4 дүгээр сургуулийн захирал Д.Цэрэнням нар семинар сургалтанд хамрагдаж байна. Орон нутагт төсөл хэрэгжих 3 сургуулийг сонгож, сургуулийн менежментийн зөвлөх багийг Боловсрол, шинжлэх ухааны даргын тушаалаар томилсон. Сургуулийн менежментийн зөвлөх багийн ажлын төлөвлөлтийг боловсруулан төслийн багт илгээсэн.

Хэлний бодлогын Үндэсний зөвлөлөөс 11 сард Монгол бичгийн сургалтыг төрийн байгууллагуудын удирдлагууд, төрийн албан хаагч нар, архив бичиг хэргийн ажилтан 80 гаруй иргэдийг хамруулсан сургалтыг зохион байгуулсан.

Шинжлэх ухаан технологи инновацийн хүрээнд:

Мон-Икс хөтөлбөрийн сургагч багш бэлтгэх семинар сургалтын 3 шатны сургалтанд, шинжлэх ухаан технологи инноваци хариуцсан ахлах мэргэжилтэн хамрагдаж, лекц, бие даалтын 64 цагийг дүүргэж, төгсөлтийн шалгалтанд хамрагдаж, сертификад гардаж авсан.

Мон-Икс хөтөлбөрийн уралдаанд 5 төсөл илгээгдсэнээс, шилдэг 40 төсөлд 2 төсөл шалгарч дараагийн шатны шалгаруулалтанд бэлтгэж, хурдсгуур сургалтанд онлайнаар хамрагдлаа.

Хоол үйлдвэрлэл, үйлчилгээний хүрээнд:

Сургуульд шинээр элссэн 1 дүгээр ангийн 411 сурагчаас эрт илрүүлэгт 406 сурагч буюу 98.7 хувьтай хамрагдсан.

Соёл, урлагийн чиглэлээр:

Аймгийн Засаг даргын Тамгын газар, аймгийн Соёл урлагийн газар, П.Бөхбат сан, Говьсүмбэр аймгийн “Боржигидай Сэцэн” утга зохиолын салбар хамтран уламжлал болгон зохион явуулдаг “Боржигидай Сэцэн-П.Бөхбат-60” Монгол туургатны яруу найргийн хоёрдахь удаагийн наадмыг 2023 оны 11 дүгээр сарын 13-ны өдөр Улаанбаатар хотноо зохион байгуулсан.

“Соёлын бүтээлч сар”-ын аян гурав дахь жилдээ соёлын засаглал ба эрхзүйн шинэчлэл, бүтээлч байдал ба мэдлэг, туршлага, соёлын хүртээмж ба хөрөнгө оруулалт, дижитал шилжилт ба шинэ боломж сэдвийн хүрээнд зохион байгуулагдаж буй сарын аяны хүрээнд салбарын ажилтан, албан хаагчдыг чадавхижуулж, хөгжүүлэх иргэд, олон нийтэд

нээлттэй тоглолт, үзэсгэлэн гаргах, хүүхэд залуучуудад зориулан тусгайлсан хөтөлбөр арга хэмжээний 30 үйл ажиллагааг төлөвлөн хэрэгжүүлж байна.

Соёлын өвийг хамгаалах тухай хуулийг хэрэгжүүлэх хүрээнд Сүмбэр сумын нутагт байрлах Түүх, соёлын үл хөдлөх 2 дурсгалт газарт Монгол Улсын Их Сургуулийн Улаанбаатар сургууль, Сүмбэр сумын Засаг даргын Тамгын газар, аймгийн Соёл, Урлагийн газар хамтран авран хамгаалах малтлага судалгааны ажлыг зохион байгуулсан.

“Ном уншлагын сар”-ын аяны хугацаанд Монгол улсын Соёлын Гавъяат зүтгэлтэн Рагчаагийн Батжаргалын “Уран бүтээлийн үзэсгэлэн” гаргаж, “Боржигидай сэцэн” салбарын уран бүтээлчид, уншигч зохиогчийн гар бичмэлүүд шүлгийн эхүүд, зохиолчийн гар бичмэл дурсамжууд, зохиол бүтээлүүдийг дэлгэн харуулж, 36 уншигч хамрагдсан. Мөн сарын аяны хүрээнд аймгийн Нийтийн номын сангаар нийт 192 уншигч хамрагдсан.

Өвөл цагийн үзвэрийн нээлтэд зориулж Боржигин чуулгын уран бүтээлчид “Боржигины түүхэн гурамсан” дуулалт жүжгүүдийг үзэгч олонд хүргэхээр ажиллаж байна. “Боржигин сэцэн” түүхэн дуулалт жүжиг нь Сэцэн вангийн хошууны үүслийг түүхэн талаас нь, сүр, хүч, дайн тулааныг харуулсан баатарлаг түүхэн дуулалт жүжиг юм. Энэхүү жүжгийг анх 2011 онд Дуу бүжгийн Боржигин чуулгын тайзнаа туурвиж “Гэгээн муза-2012” наадмаас шилдэг найруулагч, шилдэг хөгжмийн зохиолч, шилдэг тайзны зураачийн шагналуудыг тус тус хүртсэн, 2018 онд театр чуулгуудын улсын уралдаанаас шилдэг бүтээлийн “Гран при” шагналыг хүртсэн, 5 жилийн дараа дахин сэргээн тавигдаж байна.

Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн чиглэлээр:

“Хүүхэд насны эрдмийн ажил” илтгэлийн уралдаан Хүүхдийн хөгжих, нийгмийн амьдралд оролцох эрхийг хангах, хүүхдийн оролцоог идэвхжүүлэх, эрдэм шинжилгээний ажлын ач холбогдлыг таниулах, тэдэнд бие даан судлах, судалсан сэдвийн хүрээнд оновчтой санал бодолоо илэрхийлж, өнөөгийн нийгэмд тулгамдаж буй асуудлыг хөндөж, шийдвэрлэх арга замыг тодорхойлон тэдний дуу хоолойг сонсох, багаар ажиллах чадварыг эзэмшүүлэх чиглэлээр “ХҮҮХЭД НАСНЫ ЭРДМИЙН АЖИЛ” илтгэлийн уралдааныг 6 дахь жилдээ 2023 оны 10 дугаар сарын 30-аас 2023 оны 10 дугаар сарын 31-ний өдрийн хооронд амжилттай зохион байгуулсан. Тус уралдаанд аймгийн ерөнхий боловсролын 22 багийн 100 орчим хүүхдүүд чиглүүлэгч багш нартайгаа оролцож илтгэлээ танилцуулсан.

Биеийн тамир, спортын чиглэлээр:

Улсын хэмжээнд зохион байгуулагдаж буй “Эерэг хандлага-Эрүүл нийгэм” аяны хүрээнд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх, бие бялдрыг чийрэгжүүлэх, эрүүл амьдралын хэмнэлд сургах, нийгмийн оролцоог хангах зорилгоор “Түмэн дасгал” заах, бие бялдрын хөгжил чийрэгжүүлэлтийн сорил авах, суугаа волейболын тэмцээнийг зохион байгуулж, 3 багийн 23 иргэн оролцсон.

Буриад улсад зохион байгуулагдсан боксын тэмцээнд 3 тамирчин оролцож, 3 алтан медаль хүртсэн амжилт үзүүлсэн.

Ерөнхийлөгчийн цом -2023 усанд сэлэлтийн аварга шалгаруулах тэмцээнд 27 багийн 441 тамирчин оролцож, манай Говийн усчид клубын 17 тамирчин 2 багш 6 алт, 9 мөнгө, 7 хүрэл нийт -22 медаль хүртсэн амжилттай оролцсон.

Аймгийн өсвөр үеийн үндэсний бөхийн аварга шалгаруулах барилдааныг 11 дүгээр сарын 03-ны өдөр зохион байгуулсан.

Өвөр Монголын өөртөө засах орны “Алтан эмээл” хотод 11 дүгээр сарын 01-06-ны хооронд зохион байгуулагдсан Орос, Монгол, Хятад гурван улсын 20 гаруй багийн 500 тамирчин оролцсон олон улсын тэмцээнээс манай тамирчид 1 алт, 1 мөнгө, 4 хүрэл медаль хүртсэн.

Тайлант хугацаанд усан спорт сургалтын төвөөр нийт 757 иргэнд үйлчилгээ үзүүлсний 700 хүүхэд, анхан шатны сургалтад 26, давтан сургалтаар 17 иргэн хамрагдсан.

Эрүүл мэндийн талаар:

Эрүүл мэндийн үзүүлэлт

Үзүүлэлт	2022 оны	2023 оны 11 сарын
----------	----------	-------------------

	11 сар	20-ны байдлаар
Төрсөн эх	330	305
Гэрийн төрөлт	2	1
Амьд төрсөн хүүхэд	328	306
Амьгүй төрөлт	3	0
Нас баралт	77	67
Эмнэлгийн нас баралт	22	24
Хоног болоогүй нас баралт	7	7
0-1 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл	4	3
1-5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл	1	0
Эмнэлгээс гарсан хүний тоо	5419	5331
Амбулаторийн үзлэг	122497	116713
Халдварт өвчин	2586	259

Дархан-Уул аймагт зохион байгуулагдсан “Эмнэлгийн мэргэжилтний ёс зүй, төлөвшил сургалт, эрдэм шинжилгээ, онол практикийн хурал”-д аймгийн Эрүүл мэндийн газрын дэргэдэх эмч, эмнэлгийн мэргэжилтний Ёс зүйн салбар хороо, хэсгийн хороодын гишүүдийг оролцуулж, “Эрүүл мэндийг дэмжих” арга хэмжээний зардлаас 1,5 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн.

Эрүүл мэндийн яам, Эрүүл мэндийн хөгжлийн төвөөс БНХАУ-ын ӨМӨЗО-ны Олон улсын Монгол эмнэлгийн хороотой хамтран зохион байгуулсан хөдөө орон нутгийн сувилагч нарын ур чадварыг дээшлүүлэх “Сувилагчийн ур чадварыг дээшлүүлэх сургалт” хөтөлбөрт аймгийн Нэгдсэн эмнэлгийн 1 сувилагч хамрагдаж, мэдлэг чадвараа дээшлүүлсэн.

Аймгийн хэмжээнд улирлын томуугийн эсрэг вакцинаар дархлаажуулалтад 11 дүгээр сарын 20-ны өдрийн байдлаар 1603 иргэн хамрагдаж, хамралт 90.1 хувьтай үргэлжилж байна. Мөн сум, өрхийн эрүүл мэндийн төвийн дархлаажуулалтын нэгжид ажиллаж, улаанбурхан, улаануудын эсрэг нэмэлт болон товлолын дархлаажуулалтын үйл ажиллагаанд дэмжлэгт хяналтыг хийж, мэргэжил арга зүйгээр хангалаа.

Эрүүл мэндийн салбарын албан хаагчдын дунд зохион байгуулагддаг Эрүүл мэндийн газрын нэрэмжит волейболын тэмцээнд нийт 11 багийн 80 гаруй тамирчид өрсөлдөж аваргуудаа тодруулсан байна.

Эрүүл мэндийн даатгалын хэлтэс:

Аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй гэрээт 5 эрүүл мэндийн байгууллага, Улаанбаатар хотын 16 лавлагаа шатлалын эмнэлгийн 8 төрлийн тусламж үйлчилгээний анхан шатны баримтад нэхэмжлэлийн нарийвчилсан хяналтыг хийж, гэрээт 6 эмийн сангийн 1146 цахим жорыг хянаж баталгаажуулалт хийгдсэн.

Тайлант хугацаанд 65 иргэний эрүүл мэндийн даатгалын шимтгэл төлөлтийг цахимаар шалгаж, 21 иргэний шимтгэлийг и-баримт апплекейшнаар төлүүллээ.

Хөдөлмөр эрхлэлтийн чиглэлээр:

Хөдөлмөрийн зах зээлийн нэгдсэн мэдээллийн санд орон нутагт шинээр бий болсон 325 ажлын байрыг судалж, бүртгэсэн.

Шинэ ажлын байрны төрөл:

- Байнгын ажлын байр-105 буюу 32%
- Түр ажлын байр- 220 буюу 68%
- Улирлын ажлын байр-0

Шинэ ажлын байрны эх үүсвэр:

- Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр- 272(84%)
- Жижиг зээл- 6 (1.9%)
- Ажил олгогч- 47 (14.1%)

Ажилгүй, ажил хайгч иргэд, ажил олгогчдын мэдээллийг хөдөлмөрийн зах зээлийн нэгдсэн санд 21 ажил хайгч иргэний мэдээллийг оруулсан. Ажил хайгч, ажилгүй бүртгэлтэй иргэдийг

тохирох 24 ажлын байранд зуучилж, ажил орлоготой болгож, мэдээллийн санд бүртгэлжүүлсэн.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрүүдийн санхүүгийн дэмжлэгт хамрагдсан 54 иргэний гэрээний үүргийг хангуулан Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих санд 11980,0 мян, төгрөг төвлөрүүлсэн, гэрээний хэрэгжилт хангагдаагүй, гэрээний хугацаа дууссан 1 иргэнийг шүүхийн байгууллагад шилжүүлж холбогдох материалыг бүрдүүлэн өгсөн. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагааны хэрэгжилтийг хангаж төсөл хүлээн авч дууссан бөгөөд, ажлын хэсгийн гишүүд ажлын байртай танилцах ажил явагдаж дууссан. Төсөл сонгон шалгаруурах ажлыг 11 сарын 22, 23, 24-ний өдрүүдэд зохион байгууллахаар төлөвлөөд байна. Хөдөлмөрт бэлтгэх үйл ажиллагааны “Мэргэжил олгох танхимын сургалтыг цахим, дадлага хосолсон хэлбэрээр 11 сарын 06-20-ны хооронд зохион байгуулж ажил хөдөлмөр олоход хүндрэлтэй 15 иргэн, хөгжлийн бэрхшээлтэй 4 иргэнийг хамруулан сургалтыг зохион байгуулсан.

Нийгмийн халамжийн үйлчилгээ:

2023 оны 11 дүгээр сарын 20-ны байдлаар зорилтот бүлгийн иргэдэд нийгмийн халамжийн үйлчилгээг нийт 12616 иргэнд цаг тухайд нь олгож, түргэн шуурхай үйлчилсэн.

2023 оны 11 сарын хүнсний эрхийн бичгийн үйлчилгээнд аймгийн хэмжээнд 5 өрхийн 31 гишүүнд олгохоор олголт үүсгээд байна.

№	Үзүүлэлт	2023.01.01 2023.11.20
		Хүн тоо
1	Халамжийн тэтгэвэр	280
2	Нөхцөлт мөнгөн тэтгэмж	254
3	Амьжиргаа дэмжих мөнгөн тэтгэмж	242
4	Ахмад настнуудад үзүүлсэн хөнгөлөлт, тусламж	1055
5	Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд үзүүлсэн хөнгөлөлт, тусламж	148
6	Жирэмсэн болон нярай, хөхүүл хүүхэдтэй эхчүүдийн тэтгэмж	142
7	Алдарт цолтой ахмадуудад үзүүлсэн хөнгөлөлт, тусламж	8
8	Алдарт эхийн одонтой эхчүүдэд үзүүлэх мөнгөн тусламж	1458
9	Цалинтай ээж	701
10	Хүнс тэжээлийн дэмжлэг туслалцаа	280
11	Насны хишиг	743
12	Өрх толойлсон эх, эцгийн тэтгэмж	42
13	Ихэр хүүхдийн тэтгэмж	3
14	Олон нийтийн оролцоонд түшиглэлэсэн халамжийн үйлчилгээ	84
15	Хүүхдийн мөнгөн тэтгэмж	7176
Нийгмийн халамжийн сангийн дүн		12616

www.Ehalamj.mn системээр дамжуулан иргэдийн үйлчилгээг бүртгэн 0-3 хүртэлх насны хүүхэд асарсны тэтгэмжид 701 иргэний, жирэмсэн эхийн тэтгэмжид 142 иргэний тэтгэмжийг илгээсэн. Хүүхдийн мөнгөн тэтгэмж 11 сард 7176 хүүхдийн олголтыг үүсгэж илгээсэн. 2023 оны 11 дүгээр сарын 20-ны өдрийн байдлаар ахмадын хөнгөлөлт тусламжийг 18 иргэн, Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөнгөлөлт, тусламжийг 57 иргэнд үйлчилгээ үзүүлсэн. Аймгийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын салбар комиссын хурлыг 1 удаа зохион байгуулж, 4 хүүхдийн асуудлыг шийдвэрлэсэн.

ТАВ. ХӨДӨӨ АЖ АХУЙН БОДЛОГЫН ХҮРЭЭНД

Газар тариалангийн чиглэлээр:

2022, 2023 онд олгосон нийт 85 хүлэмжийн ашиглалтыг тооцоход Баянтал сум 78%, Шивээговь сум 60%, Сүмбэр сум 60% -ийн ашиглалттай байна.

Аймгийн дүнгээр нийт 543.28 тн ургац хурааснаас төмс 167.14 тн, хүнсний ногоо 272.14 тн, ногоон тэжээл 104.0 тн байна. “Намрын ногоон өдрүүд-2023” улсын үзэсгэлэн худалдаанд нийт 5 аж ахуйн нэгж оролцож, 2 аж ахуйн нэгж шагналт байранд шалгарсан.

Мал аж ахуйн хаваржилтын талаар:

Засгийн газрын 2023 оны 279 дүгээр тогтоол, Ерөнхий сайдын 03 албан даалгавар, аймгийн Засаг даргын 01 албан даалгавар, аймгийн Засаг даргын 2023 оны А/216 дугаар захирамжийн хүрээнд аймгийн хэмжээнд 2023-2024 оны мал аж ахуйн салбарын өвөлжилт, хаваржилтыг өнөтэй давах бэлтгэл ажлыг холбогдох эрх зүйн акт, эрх бүхий этгээдийн шийдвэр, өгсөн үүргийн хүрээнд зохион байгуулж ажилласан.

Мал аж ахуйн салбарын өвөлжилт, хаваржилтын бэлтгэл хангасан нэгдсэн дүн-Говьсүмбэр аймаг

Д/Д	Сум, дүүргийн нэр	Малчдын өвс, тэжээл бэлтгэл /хүснэгт 5-17/	Аймгийн аюулгүйн нөөц бэлтгэл /хүснэгт 6-7*/	Сумын аюулгүйн нөөц бэлтгэл /хүснэгт 6-7/	Худгийн бэлэн байдал /хүснэгт 7-	Малын усан хангамж /хүснэгт 7-	Малчин өрхийн хашаа бууцны хангамж /хүснэгт	Өрхийн өвөлжилтийн бэлтгэл /хүснэгт 9-	Өвөлжилтийн бэлтгэл хангасан ерөнхий дүн /хүснэгт 10-ын 1-7-
		Хувь	Хувь	Хувь	Хувь	Хувь	Хувь	Хувь	Хувь
	А	1	2	3	4	5	6	7	8
1	Баянтал	40.3		15.0	86.2	95.5	90.0	81.1	68.0
2	Сүмбэр	73.5		100.0	95.4	95.8	90.0	84.4	89.9
3	Шивээговь	43.5		20.0	95.4	85.3	90.0	78.8	68.8
	Дүн	64.8	100.0	45.0	92.3	92.2	90.0	80.5	80.6

Отор нүүдэл: Малх отрын бүсийн бэлчээрийн даацын судалгаагаар хонин толгойд шилжүүлснээр 89.0 мян.то мал өвөлжиж хаваржих боломжтой тооцоо гарсан. Малах орон тооны бус зөвлөлийн хурлыг 2023 оны 10 дугаар сарын 21-ний өдөр Сүмбэр сумын ЗДТГ зохион байгуулж, Малх отрын бүсэд 2023 -2024 оны өвөл, хавар Говьсүмбэр аймгийн Сүмбэр сумаас хонин толгойд шилжүүлснээр 75.0 мян.тол мал, Төв аймгийн Баянжаргалан сумаас хонин толгойд шилжүүлснээр 14.0 мян.тол мал отроор оруулахаар шийдвэрлэсэн.


Малчдаас отроор явах өрхийн судалгааг 11 дүгээр сарын 20-нд дахин гаргасан 60 өрхийн 30.2 мян.тол мал оторт гарах мэдээтэй байгаагаас 11 өрхийн 8.8 мян.тол мал Дундговь аймгийн Баянжаргалан, Өндөршил, Цагаандэлгэр суманд отроор байна.

Сумдын хөдөө аж ахуйн тасгийн бүртгэл хариуцсан мэргэжилтнүүдийг чадавхижуулах зорилгоор Малын үндэсний бүртгэл мэдээллийн нэгдсэн сангийн системийн хөгжүүлэлт хийсэн “Дижитал медиал” ХХК-аас сургагч багш нарыг урьж, бүртгэлийн системийн сургалтыг зохион байгуулсан. Сургалтад сумдын хөдөө аж ахуйн тасгийн мэргэжилтнүүд болон Хүнс, хөдөө, аж ахуйн газрын мал үржлийн алба “Сүмбэр хонь Цөм сүрэг, үржлийн төв”-ийн мал зүйч нарыг хамруулсан.

Хоршоо, жижиг дунд үйлдвэр, ахуйн үйлчилгээний чиглэлээр:

2023 оны 11 дүгээр сард Жижиг дунд үйлдвэрийн газраас ирүүлсэн удирдамжийн дагуу хөнгөлөлттэй зээлэнд хамрагдсан аж ахуйн нэгжид хяналт, мониторинг хийж байна. Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас 21 аж ахуй нэгжид 1.596 тэрбум төгрөгийн санхүүгийн дэмжлэг олгосон байна. Үүнд: 2019 онд 9 аж ахуй нэгжид 450.0 сая.төг, 2020 онд 6 аж ахуй нэгжид 448.0 сая.төг, 2022 онд 3 аж ахуй нэгжид 300.0 сая. төг, 2023 онд 3 аж ахуй нэгжид

398.0 сая.төг байна. Жижиг дунд үйлдвэрийн газраас 2019 онд олгосон 450.0 сая.төг буюу 9 зээлдэгчээс 4 зээлдэгч зээлээ бүрэн барагдуулж, хэвийн ангилалд байна. Зээлийн үлдэгдэлтэй 5 ААНБ 139.1 сая төг-ийн зээлийн үлдэгдэлтэй байна. 2020 онд олгосон 448.0 сая.төг буюу 6 аж ахуйн нэгжийн зээлийн үлдэгдэл 364.6 сая.төг байна. Үүнээс хэвийн-1, хугацаа хэтэрсэн-2, муу зээлийн ангилалд-3 байна. 2022 онд олгосон 300.0 сая төг буюу 3 аж ахуйн нэгж гэрээний дагуу үндсэн зээлийн эргэн төлөлт 11 сараас эхэлнэ. Гүйцэтгэлийн аудитаар зөрчилтэй дүгнэлттэй, төлөлт хийгдээгүй 5 аж ахуй нэгжид мэдэгдэл өгч тооцоо нийлсэн акт үйлдсэн. Шүүхэд нэхэмжлэх үүсгэх хүсэлтийг Жижиг дунд үйлдвэрийн газарт хүргүүлсэн. Нийт дүн 587'930'259.00 төгрөг байна. Шалгалтын дүн эцэслээгүй.



Сумдад Хоршоо хөгжүүлэх сангийн чанаргүй зээлийн хэмжээг бууруулах зөвлөмжийг хүргэж улирал бүр зөвлөмжийн хэрэгжилт авч, хяналт тавьж ажилласан. Зөвлөмжийн хэрэгжилт хувьтай байна. Хоршоо хөгжүүлэх сангийн журамд 10 дугаар сард өөрчлөлт оруулсан бөгөөд журмын дагуу сумдын хоршоо хөгжүүлэх сангийн үйл ажиллагаанд дотоод хяналт, мониторинг хийж байна. Сүмбэр сумын Хоршоо хөгжүүлэх сангийн материал авлигатай тэмцэх газраас хүргүүлснээс шалтгаалж, Сүмбэр сумын Хоршоо хөгжүүлэх сангийн үйл ажиллагаанд хяналт мониторинг эхлээгүй байна.

Сумдаар харуулбал:

Сумын нэр	2022 онд муу зээлийн тоо, хөрөнгийн хэмжээ		2023 он муу зээлийн тоо, хөрөнгийн хэмжээ		Буурсан хувь
	тоо	хөрөнгө	тоо	хөрөнгө	
Сүмбэр	42	503'815'423.00	32	332'432'322.00	34%
Шивээговь	21	90'894'252.00	14	60'638'440.00	33.2%
Баянтал	11	95'975'088.00	6	64'802'063.00	32.4%
Нийт	74	690'685'763.00	52	457'872'825.00	33.7%

Аймгийн Засаг дарга, Сүмбэр сумын Засаг дарга, Хүнс, хөдөө аж ахуйн газартай хамтран орон нутгийн ахуй үйлчилгээ эрхлэгч 30 төлөөлөлтэй уулзаж арга хэмжээний үр дүнг хэлэлцэн өнөөгийн байдал тулгамдаж буй асуудлаар санал солилцов.

Шинэ хөдөө” төслийн санхүүжилтээр 120ш оёдлын машин, 4ш уурын индүү, товч хадах, товчны нүх гаргах, бөхөлгөөний машин тус бүр 2ш, 120 кв талбай бүхий 5ш хүлэмж зэрэг нийт 130 ширхэг 119.2 сая төгрөгийн тоног төхөөрмжийн дэмжлэг үзүүлсэн. Үүнд: Хөдөөгийн багийн бүлгийн зохион байгуулалтай малчин эмэгтэйчүүд 3 бүлэг, орон нутгийн 10 багийн

өрхийн үйлдвэрлэл эрхлэгч, ахуйн үйлчилгээний төв, сумдад гэрээний дагуу ашиглуулахаар олгосон байна.

Оёдол, эсгүүр сонирхогч хөдөлмөрийн насны хүмүүсийн хэрэгцээг судлан эсгүүрийн чиглэлээр мэргэжил эзэмших сонирхолтой ахуй үйлчилгээ эрхлэгч 15 хүн, 5 Хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг “Эсгүүрийн” чиглэлээр эрх бүхий сургалтын байгууллага Хүнс, хөдөө аж ахуйн газартай хамтран зохион байгуулж байна. Сургалтыг 2023 оны 11 дүгээр сарын 15-ны өдрөөс эхлэн Хүнс, хөдөө аж ахуйн газрын сургалтын танхимд эхлэн явагдаж байна. “Явуулын ахуй үйлчилгээ”-г 11 дүгээр сарын 10-наас 15-ны өдрүүдэд Баянтал сум, Шивээговь сумын малчид, багийн иргэдэд хүргэсэн. Арга хэмжээнд нийт 150 гаруй иргэдэд үйлчилгээ үзүүлсэн байна.

Хөдөөгийн багийн иргэдэд “Явуулын ахуй үйлчилгээ”-г үзүүлэх арга хэмжээний үеэр Зээлийн батлан даалтын сан, Хөдөөгийн хөгжлийн төслийн нэмэлт санхүүжилт, Жижиг, дунд үйлвэрлэлийг хөгжүүлэх, Байгаль орчныг хамгаалах 2 үе шаттай зээлийн төсөл, “Орон нутгийн ипотекийн зээлийн урьдчилгаа төлбөрийн батлан даалтын судалгаа, нөхцөл, тавигдах шаардлага”-ыг сурталчлав. Мөн Хуванцар савны хор уршиг, тэмдэг тэмдэглэгээний талаар гарын авлага тараах Хөдөөгийн багийн малчид, бизнес эрхлэгч, хоршоодод, зээлийн бодлого, үйл ажиллагааг сурталчилан таниулж, мэргэжил арга зүйн зөвөлгөө өгөх сургалтын гарын авлага тараах, Мэдлэг бататгах танин мэдэхүйн АХА тэмцээн зэргийг зохион байгууллаа.

Газар тариалангийн чиглэлээр:

Ургацын урьдчилсан балансаар төмс 167.12 тн, хүнсний ногоо 268.3 тн, жимс, жимсгэнэ 1.83 тн хураан авахаар тооцоолсон. Ургац хураалтын эцсийн дүнгээр 167.14 тн төмс, 272.15 тн хүнсний ногоо, жимс, жимсгэнэ 1.83 тн хураан авсан. Үүний үр дүнд төмсний хангамж 27.44%, хүнсний ногооны хангамж 20.62% байна.

Эргэлтийн талбай 94 га-д хүрсэн ч талбайн ашиглалт 72.85%, услалтын системийн ашиглалт 51.5%. Дотооддоо үйлдвэрлэсэн газар тариалангийн бүтээгдэхүүнийг талбайн түүхийн карт, ургамал хамгаалах бодис хэрэглээгүй зэргийг үндэслэн сумдын ХАА-н тасгаас 25.6 тн бүтээгдэхүүнд гарал үүслийн гэрчилгээг олгож ажиллалаа. 55.2 тн төмс, хүнсний ногоог өвлийн улиралд нөөцөлсөн.

ХҮНСНИЙ НӨӨЦИЙН ТАЛААР:

Хүнсний нөөцийн бодит мэдээллийг 3 сумаас авч нэгтгэсэн. Үүнд: Аймгийн дүнгээр мах 25.24 тн буюу 15, гурил 35.16 тн буюу 25, сүү 2.39 тн буюу 1, төрөл бүрийн будаа 21.44 тн буюу 31, төмс 7.58 тн буюу 5, хүнсний ногоо 5.5 тн буюу 2, элсэн чихэр 3.6 тн буюу 8, давс 1.8 тн буюу 7, савласан ус 23.71 тн буюу 1, өндөг 7.6 тн буюу 27, ургамлын тос 4.26 тн буюу 14 хоногийн нөөцтэй байна.

№	Хүнсний нэр төрөл	Сүмбэр сум			Баянтал		Шивээговь	
		Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Хоногийн нөөц	Тоо хэмжээ	Хоногийн нөөц	Тоо хэмжээ	Хоногийн нөөц
1	Малын мах	тн	24	20	0.15	1	1.092	3
2	Гурил	тн	29.8	30	3.53	38	1.831	6
3	Гурилан бүтээгдэхүүн	тн	1.79	1	2.361	3	0.225	0
4	Төрөл бүрийн будаа	тн	17.6	35	2.796	61	1.04	7
5	Сүү	тн	1.6	1	0.223	1	0.572	1
6	Өндөг	тн	4.9	24	0.055	3	2.649	45
7	Ургамлын тос	тн	3.1	13	0.247	11	0.913	14
8	Төмс	тн	6.2	8	0.31	3	1.069	3

9	Хүнсний ногоо	тн	4.8	3	0.22	1	0.494	1
10	Элсэн чихэр	тн	2.56	8	0.565	18	0.497	5
11	Давс	тн	1.42	7	0.264	14	0.198	3
12	Савласан цэвэр ус	тн	17.8	1	0.0264	1	5.885	1

Үнийн мэдээг өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад дотооддоо үйлдвэрлэж буй хонь, адуу, ямаа, үхрийн мах 1000 төгрөгөөр, төмс 100 төгрөгөөр, хүнсний ногоо дунджаар 200 төгрөгөөр буурч, импортын бүтээгдэхүүн харьцангуй тогтвортой байна. 2023 оны 11 дүгээр сарын 21-ний байдлаар гол нэрийн барааны үнэ:

№	Бараа бүтээгдэхүүн		Дээд үнэ төг	Доод үнэ төг	Өссөн буурсан
1	Үхрийн мах	Ястай	11000	10000	-1000
		Цул	13000	12000	-1000
2	Хонины мах	Ястай	9000	8000	-1500
		Цул	10000	9000	-1500
3	Адууны мах	Ястай	8500	7500	-1000
		Цул	9000	8500	-1000
4	Ямааны мах	Ястай	8000	7000	-1000
		цул	9000	8000	-1000
5	Тахианы мах	Гуя	14000	12000	
		мөч	12000	11500	500
6	Лууван	монгол	2500	1900	200
		хятад			
7	Төмс	монгол	1800	1400	-100
		хятад			
8	Байцаа	монгол	2000	1800	-500
		хятад			
9	Чинжүү	монгол	7500	6000	-500
		хятад			
10	Манжин	монгол	3000	2500	300
		хятад			
11	Сонгино бөөрөнхий	Монгол	3000	2500	-200
		Хятад	2350		
12	Помидор	монгол	10000	6000	2000
13	Өргөст хэмх	монгол	8000	6000	2000
14	Элсэн чихэр		5200	4600	100
15	Будаа	Цагаан задгай кг	3800	3650	
		Шар слава кг			
		Гурвалжин будаа кг	8500	4100	1000
16	Сүү	Задгай			
		Сүү ХХК 0,5л			
		Сүү ХХК 1л	5800	5400	200
17	Тараг	Задгай			
		Сүү ХХК 1л цөцгийтэй тараг	6200	4500	100
18	Талх	Чойр талх	2500	2150	
19	Өндөг	ОХУ	680	550	30
		Монгол			
		Задгай дээд			
		Задгай 1-р зэрэг	2900	2600	100
		Задгай 2-р зэрэг			

20	Алтан тарианы гурил	Савласан д/дээд /			
		Савласан дээд	3200		100
		Савласан 1-р зэрэг	2700		100
		Савласан 2-р зэрэг	1800		-100
21	Ургамлын тос	Олейна	12000	10000	
		Алтан	10000		
22	Гоймон	Алейка			
		Лапша	2000	1800	

ЗУРГАА. БАЙГАЛЬ ОРЧИН, ҮЙЛДВЭР, ҮЙЛЧИЛГЭЭ,

Хүрээлэн буй орчны бохирдол, газрын асуудлын хүрээнд:

Ойн менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд байгалийн ойн санд шинэ тарилт хийхээр Хэрлэн гол дагуу 3га талбай болон Чойрын богд ууланд 200 бургасыг Сум дундын Ойн ангиар гүйцэтгүүлсэн.

“Агнуурын бүс нутгийн болон Тусгай хамгаалалттай газар нутагт ерөнхий агнуур зохион байгуулалтын судалгааг хийн гүйцэтгэж, ан агнуурын менежментийн төлөвлөгөөг боловсруулан аймгийн ИТХ-аар хэлэлцүүлэн батлуулсан.

“Нийтийн эзэмшлийн гудамж, талбайд мод, бут тарьж ургуулсан иргэн, аж ахуйн нэгж байгууллагад мөнгөн урамшуулал олгох журам-ыг аймгийн ИТХ-ын 2023 оны 11 дүгээр сарын 13-ны өдрийн 09 дүгээр тогтоолоор батлууллаа.

2023 онд мод тарьсан 26 иргэн, 1 аж ахуйн үйлдвэрлэлийн газрын 2803 ширхэг мод, сөөгийн урамшуулалд 31 692 500 төгрөгийг олгохоор аймгийн Засаг даргын захирамж гарсан.

Хүрээлэн буй орчны бохирдлыг бууруулах хүрээнд:

Хог хаягдлыг ангилан ялгах, дахин ашиглах, хог хаягдлыг баялаг болгож, байгальд ээлтэй, хор нөлөөгүй амьдрах зөв дадал бий болгох зорилгоор Политехник коллеж, Ерөнхий боловсролын 2 дугаар сургуульд “Бөмбөрцгийн Сүмбэр” Хүүхдийн байгууллагын тэргүүн Ж.Бямбасүрэн 2023 оны 11 дүгээр сарын 22 , 23-ны өдрүүдэд сургалт зохион байгуулсан.

Тус сургалтад Политехник коллежийн ой нөхөн сэргээлт, барилга, цахилгааны 1, 2, 3-р курсийн оюутан нийт 40 гаруй хүүхэд оролцсон. Ерөнхий боловсролын 2-р сургуулийн 30 хүүхэд хамрагдсан. 7 ангийн сурагчид идэвх санаачилгатай оролцож, хаягдал зайгаар удирдлагатай машиныг хөдөлгөөнд оруулж, сахлын машин, оёдлын машин, гэрэл, утасны цэнэглэгч гэх мэтийн эвдэрсэн болон ашиглагдахаа больсон ахуйн хэрэглээний зүйлсийг засаж хэрэглээг хэвийн болгож дахин ашиглах боломжтой болгосон. Амжилттай бүтээл хийсэн 5 сурагчийг өргөмжлөл, үнэ бүхий зүйлээр шагнасан. Сургалтад хамрагдсан хүүхдүүд ашиглагдахаа больсон, хэрэгцээгүй болсон эд зүйлс бүхэн хог биш хэрэглээг нь өөрчилж эсвэл засварлан дахин ашиглах боломжтой гэсэн мэдлэг ойлголт авсан. Сургалтыг зохион байгуулснаар хүүхдүүдийн идэвх оролцоог нэмэгдүүлж, бусдад хог хаягдлыг дахин ашиглах талаарх мэдээлэл хүргэх, цаашид бусад хүүхдүүдэд үлгэр дуурайлал үзүүлэх, санаа сэдэл өгөх, хог хаягдлыг бууруулах олон талын мэдээлэл, мэдлэг өгсөн үр дүнтэй үйл ажиллагаа боллоо.

Байгаль орчны үнэлгээ, усны асуудлын хүрээнд:

Аймгийн 2023 оны Байгаль хамгаалал нөхөн сэргээх арга хэмжээний зардлын 19.9 сая төгрөгийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн “Уруйн үерийн улмаас 2022-2023 онд эвдрэлд орсон Цоорхойн рашааны тохижилт, Уулзварын гол, Асгана булгийн хамгаалалтын хашааг сэргээн засварлах” ажил, 7.0 сая төгрөгийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн “Хөндлөн булгийн эхийг хашиж хамгаалах ажил”-ын гүйцэтгэлийг хүлээн авсан.

Иргэн, аж ахуйн нэгжээс ирүүлсэн хүсэлтийн дагуу Байгаль орчны нөлөөллийн ерөнхий үнэлгээний дүгнэлт 4, ус ашиглуулах дүгнэлт 1 гаргасан.

Газрын харилцаа, барилга, хот байгуулалт, хөрөнгө оруулалтын талаар:

Аймгийн хэмжээний 10 багийн заагийг аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2023 оны 11 дүгээр сарын 13-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлэн 2023 оны 07 дугаар тогтоолоор батлуулан газар зохион байгуулалт, геодези зураг зүйн газарт хүргүүлсэн. Мөн аймгийн

хэмжээний тэг гортиг болон газрын нэгдмэл сангийн ангилал хооронд шилжүүлэх асуудлыг сумдын Засаг дарга нараас санал авч аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хуралд өргөн барьж хэлэлцүүлэхээр бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна.

Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 105 дугаар тогтоолын дагуу 2023 оны 11 дүгээр сарын 20-21-ний өдрүүдийн хооронд Баянтал суманд 5 байршилд 58 иргэний өмчлөлийн материалыг авах ажлыг Баянтал сумын Засаг даргын Тамгын газартай хамтран зохион байгуулсан боловч 2023 оны 11 дүгээр сарын 22-ны өдрийн байдлаар 52 иргэний материалыг хүлээн аваад байна.

Аймгийн хэмжээнд мэргэжлийн эрх бүхий геодезийн тусгай зөвшөөрөлтэй 1 аж ахуйн нэгж үйл ажиллагаа эрхэлдэг бөгөөд тус аж ахуйн нэгжийн үйл ажиллагаанд 2023 оны 11 дүгээр сарын 15-ны өдөр хяналт шалгалтыг хийн ажилласан.

Сумдын газар зохион байгуулалтын төлөвлөгөө боловсруулах ажлын хэсгийн гишүүдэд мэргэжил арга зүйгээр хангах, хоорондын үйл ажиллагааны уялдаа холбоог сайжруулах, туршлага судлуулах, ур чадварыг дээшлүүлэх зорилгоор Сумдын Газар зохион байгуулалтын төлөвлөгөө боловсруулах ажлын хэсгийн гишүүд, Сумдын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын нарийн бичгийн дарга нар Багийн Иргэдийн нийтийн хурлын дарга нарт 2023 оны 11 дүгээр сарын 02-ны өдөр сургалт зохион байгуулан ажилласан.

Аймгийн Засаг даргын 2023 оны 11 дүгээр сарын 10-ны өдрийн А/326 дугаар захирамжийг үндэслэн газар, эзэмших, ашиглах эрхийн гэрчилгээний 2 байршилд дуудлага худалдааг цахимаар зохион байгуулахаар зарлаж Зарыг Зууны мэдээ сонин, байгууллагын сайт, газрын биржийн цахим системд байршуулсан. Тухайн дуудлага худалдаа 2023-12-14 цагт цахимаар зохион байгуулагдана.

Барилга, хот байгуулалтын хэлтэс:

Баянтал суманд хийгдэх 4 дүгээр сургуулийн спорт заалны дээврийн засварын ажлыг бүрэн хийж дууссан. Байгаль орчны газарт хийх ажлын шал, хана таазны эмульс замаскийн ажил болон ариун цэврийн өрөөний засварын ажил хийгдсэн байна. АЗДТГ-ын засварын ажил ханын тэгшилгээ замаск, таазны ажил хийгдсэн. Татварын байрны засварын ажил хана таазны тэгшилгээ хийгдсэн. Барилгын ажлын гүйцэтгэл 70 хувьтай үргэлжилж байна.

Говьсүмбэр аймгийн халуун усны барилгын ажил: Барилгын ажлын дотор хананы өрлөгийн ажил дууссан. Дотор ханын шавардлагын ажил болон Гадна цэвэр ус татах ажил, цахилгааны ажлууд хийгдэж байна. Барилгын ажил 80 хувийн гүйцэтгэлтэй байна.

Аймгийн төвийн 2,8км авто замын ажил: Авто замын ажлын гүйцэтгэл 95 хувьтай босоо тэмдэг тэмдэглэгээ замын хөвөө цэвэрлэх ажил болон Улсын комисст хүлээлгэн өгөх бэлтгэл ажил хийгдэж байна.

Худалдаачны гудамжны тохижилт: Дугуйн замын асфальт хучилт хийгдсэн. Гэрэлтүүлгийн ажлууд хийгдэж байна. Ажлын гүйцэтгэл 80 хувь

0,36км автозамын ажил: Авто замын ажлын гүйцэтгэл 95 хувьтай. Улсын комисст хүлээлгэн өгөх бэлтгэл ажил хийгдэж байна.

Боржигон чуулгын барилга: Барилгын ажлын гүйцэтгэл нийт гүйцэтгэл 60 хувьтай. Барилгын талбайд дотор хана шаврын ажил хийгдэж байна. Гадна фасадын материал барилгын ажлын талбайд буусан байна.

Орон нутгийн өмчийн талаар:

Төсвийн ерөнхийлөн захирагчид 2023 онд нийт 8,279,947.0 мянган төгрөгийн төсөвт өртөг бүхий 26 бараа, ажил, үйлчилгээ худалдан авч хэрэгжүүлэхээр төлөвлөн ажилласан байна. Үүнээс 26 тендер шалгаруулалт зарлаагүй байна. Худалдан авах ажиллагааны явц 70 хувьтай байна. Үйл ажиллагааны явцад төлөвлөгөөнд өөрчлөлт оруулаагүй. Төлөвлөгөөний биелэлтийг санхүүжилтийн эх үүсвэрээр нь ангилбал:

Улсын төсвийн хөрөнгө оруултаар 4,194,800.0 мянган төгрөгийн төсөвт өртөг бүхий 1 төсөл арга хэмжээ төлөвлөгдсөнөөс:

- Үнэлгээ хийгдэж байгаа төсөл арга хэмжээ – 1 / 85,000.0 мянган төгрөг/,

- Гэрээ байгуулах эрх олгосон төсөл арга хэмжээ -1 / 4,109,800.0 мянган төгрөг/
Төлөвлөгөөний биелэлт 50 хувь.

Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 1,023,869,4 мянган төгрөгийн төсөвт өртөг бүхий 7 төсөл арга хэмжээ төлөвлөгдснөөс:

- Гэрээ байгуулах эрх олгосон төсөл арга хэмжээ – 7 / 1,023,869.4 мянган төгрөг/
Төлөвлөгөөний биелэлт 100 хувь.

“Орон нутгийн хөгжлийн сан”-ийн хөрөнгөөр 2,451,959.1 мянган төгрөгийн төсөвт өртөг бүхий 14 төсөл арга хэмжээ төлөвлөснөөс:

- Гэрээ байгуулах эрх олгосон төсөл арга хэмжээ – 13 / 2,381,959.1 мянган төгрөг/
Төлөвлөгөөний биелэлт 98 хувь.

“Авто замын сан”-ийн хөрөнгөөр 440,616.5 мянган төгрөгийн төсөвт өртөг бүхий 1 ажил төлөвлөснөөс:

- Гэрээ байгуулах эрх олгосон төсөл арга хэмжээ – 1 / 440,616.5 мянган төгрөг.
Төлөвлөгөөний биелэлт 100 хувь.

“Байгаль хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардал”-аар 28,702.0 мянган төгрөгийн төсөвт өртөг бүхий 1 ажил төлөвлөснөөс:

- Гэрээ байгуулах эрх олгосон төсөл арга хэмжээ – 1 / 28,702.0 мянган төгрөг
Төлөвлөгөөний биелэлт 100 хувь.

“Бусад хөрөнгө оруулалт”-аар 28,702.0 мянган төгрөгийн төсөвт өртөг бүхий 1 ажил төлөвлөснөөс:

- Гэрээ байгуулах эрх олгосон төсөл арга хэмжээ – 1 / 100,000.0 мянган төгрөг
Төлөвлөгөөний биелэлт 100 хувь
- Хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, 8.2-т заасныг үндэслэн худалдан авах ажиллагаанд мөрдөх журмыг сонгон зарласан байна. Үүнд:
- Нээлттэй тендер шалгаруулалтын аргаар зарласан – 13
- Харьцуулалтын аргаар – 9
- Зөвлөх үйлчилгээний тендер – 4

Орон нутгийн өмчийн талаар:

“Төв АЗЗА” ТӨХК-ний үндсэн хөрөнгөд бүртгэлтэй манай аймагт байрлах 11-р байрны 1 дүгээр орцыг төрийн өмчөөс орон нутгийн өмчид шилжүүлэн авч, одоо амьдарч буй 12 айл, өрхтэй түрээсийн гэрээ байгуулан, түрээсийн орлогод хяналт тавин ажиллаж байна.

Орон нутгийн өмчтэй хуулийн этгээдээс ирүүлсэн хөрөнгө акталж данснаас хасах, элэгдэл хорогдлын шимтгэлээрээ анхны үнийг нөхсөн боловч цаашид ашиглах боломжтой эд хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох, орон нутгийн хөгжил сан, орон нутгийн хөрөнгө оруулалтаар худалдан авсан бараа, ажил, үйлчилгээг байгууллагад бүртгэлжүүлэх, актлах саналтай байгаа эд хөрөнгийн дахин ашиглах, балансаас балансад шилжүүлэх, үндсэн хөрөнгөд бүртгэлтэй хөрөнгийг эргэлтийн хөрөнгөд бүртгэх хүсэлтүүдийг нэгтгэн шийдвэрлүүлсэн. Үүнд: Улсын төсвийн 2019 оны хөрөнгө оруулалтын хүрээнд бий болсон 5,946,379,440.0 (таван тэрбум есөн зуун дөчин зургаан сая гурван зуун далан есөн мянга дөрвөн зуун дөч) төгрөгийн үнэ бүхий 1 нэр төрлийн хөрөнгө, аймгийн 2023 оны Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтын хүрээнд бий болсон 273,870,458.0 (хоёр зуун далан гурван сая найман зуун далан мянга дөрвөн зуун тавин найм) төгрөгийн үнэ бүхий 6 нэр төрлийн хөрөнгө, аймгийн 2023 оны Орон нутгийн хөрөнгө оруулалтын хүрээнд бий болсон 87,018,161.0 (наян долоон сая арван найман мянга нэг зуун жаран нэг) төгрөгийн үнэ бүхий 1 нэр төрлийн хөрөнгийг бүртгэлжүүлэх саналыг боловсруулан нэгтгэж, аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлаар шийдвэрлүүлэн, захирамжийг холбогдох байгууллагад хүргүүлэн, хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллаж байна.

Орон нутгийн өмчийн газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй 50,880,500 (тавин сая найман зуун наян мянга таван зуу) төгрөгийн балансын үнэ бүхий 14 нэр төрлийн хөрөнгийг аймгийн Стандарт хэмжилзүйн хэлтэст балансаас балансад шилжүүлэх саналыг боловсруулан нэгтгэж, аймгийн ИТХ-аар шийдвэрлүүлэн, захирамжийг холбогдох байгууллагад хүргүүлэн, хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллаж байна.

Орон нутгийн өмчит 7 байгууллагын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй ашиглалтын хугацаа дууссан, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн, сэргээн засварлах боломжгүй болсон нийт 52 нэр төрлийн 104,965,430.1 (нэг зуун дөрвөн сая есөн зуун жаран таван мянга дөрвөн зуун гучин

төгрөг нэг мөнгө) төгрөгийн хөрөнгийг акталж, данснаас хасч, шууд устгах саналыг боловсруулан нэгтгэж, аймгийн ИТХ-аар шийдвэрлүүлэн, захирамжийг холбогдох байгууллагад хүргүүлэн, хэрэгжилтэнд хяналт тавьсан.

“Тохижилт Сүмбэр” ОНӨААТҮГ газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй ашиглалтын хугацаа дууссан, элэгдэл хорогдлын шимтгэлээрээ балансын үнээ нөхсөн, сэргээн засварлаж цаашид ашиглах боломжгүй болсон 36,000,000.0 (гучин зургаан сая) төгрөгийн балансын үнэ бүхий 1 автомашиныг сэлбэг материал хоёрдогч түүхий эдээр худалдах саналыг боловсруулан нэгтгэж, аймгийн ИТХ-аар шийдвэрлүүлэн, захирамжийг холбогдох байгууллагад хүргүүлэн, хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллаж байна.

Шинэ хөдөө төслийн хүрээнд худалдан авсан 5 нэр төрлийн оёдлын машин, 2 нэр төрлийн хүлэмж, үрлэгчийг бүртгэлжүүлэх саналыг боловсруулан нэгтгэж, аймгийн ИТХ-аар шийдвэрлүүлэн, захирамжийг холбогдох байгууллагад хүргүүлэн, хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллаж байна.

Аймгийн Засаг даргын 2023 оны 06 дугаар сарын 26-ны өдрийн А/201 дугаар захирамжаар “Цөм сүргийн үржлийн төв” ОНӨААТҮГ газрын үйл ажиллагаанд хяналт шалгалт хийж, дүгнэлт гаргах ажлын хэсэг байгуулагдан, удирдамжийн дагуу манай газраас орон нутгийн өмчийн хөрөнгийн хадгалалт, хамгаалалт, бүртгэл, ашиглалт, зарцуулалтын байдалд хяналт хийж ажилсан.

2023 оны түрээсийн орлого 11 дүгээр сарын 24-ний өдрийн байдлаар 36,8 сая төгрөг байна.

Стандарт хэмжил зүйн хэлтэс:

Савласан бүтээгдэхүүний тоон хэмжээнд төлөвлөгөөт бус урьчилан сэргийлэх хяналт шалгалтыг хэмжил зүйн хяналтын улсын байцаагч О.Долгион 2023 оны 10 дугаар сарын 16-ны өдрөөс 10 дугаар сарын 25-ны өдрийн хооронд аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа худалдаа үйлчилгээ эрхлэгч болон хүнсний цехүүдийг хамруулан гүйцэтгэлээ.

Урьдчилан сэргийлэх шалгалтад 6 аж ахуй нэгжийг хамруулсан бөгөөд 66.8% буюу 4 аж ахуй нэгж нь хэмжих хэрэгсэл болох жингээ баталгаажуулалтад хамруулаагүй, 16.6% буюу 1 аж ахуй нэгжийн хэмжих хэрэгсэл болох жингийн баталгаажуулалтын хугацаа дууссан болон 16,6% буюу 1 аж ахуй нэгжийн хэмжих хэрэгсэл болох жин улсын баталгаажуулалтад хамрагдсан. Шинээр баригдаж байгаа орон сууцны барилгад суурилуулж буй ус, дулаан, цахилгааны тоолуурын хэмжлийн нэгдмэл байдалд урьдчилан сэргийлэх хяналт шалгалтыг Хэмжил зүйн хяналтын улсын байцаагч О.Долгион 2023 оны 10 дугаар сарын 16-ны өдрөөс 10 дугаар сарын 25-ны өдрийн хооронд гүйцэтгэлээ. 1 аж ахуйн нэгжийн 2 шатахуун түгээгүүрт ээлжит баталгаажуулалт хийсэн.

Тохирлын гэрчилгээ авах хүсэлт гаргаж, үнэлгээ хийлгүүлсэн 5 аж ахуйн нэгж байгууллагад тохирлын гэрчилгээ олгосон. Иргэн аж ахуй нэгжийн хүсэлтээр ирүүлсэн 7 дээж нийт 7 сорьцонд 18 үзүүлэлтээр хими, нян судлалын хорио цээрийн шинжилгээг гүйцэтгэн хяналт тавьж, хариуг баталгаажуулсан бөгөөд 118,500 төгрөгийн орлого төвлөрүүлсэн. Шаардлага хангаагүй 2 сорьц илрээгүй. Лабораторийн эрхлэгч, нян судлалын шинжээч нар 2023 оны 11 дүгээр сарын 23-24-ний өрдүүрдэд MNS ISO 17025:2018 “Сорилтын болон шалгалт тохируулгын лабораторийн чадавхид тавих ерөнхий шаардлага” сэдэвт 2 өдрийн сургалтад хамрагдсан.

Говьсүмбэр аймгийн цахим үйлчилгээний талаар

Говьсүмбэр аймаг дахь ХУРДАН төвөөс иргэд 10 дугаар сарын 25-наас 11 дүгээр сарын 25-ны өдрүүдэд 617 үйлчилгээ авсан. Үүнд:

- Лавлагаа тодорхойлолт – 577
- Нэг буюу олон шатлалт үйлчилгээ – 40

Гар утасны GSIGN аппликейшн дээр суурилсан тоон гарын үсгийг 10 иргэнд олгосон. Авто тээврийн төв, Цагдаагийн хэлтэстэй хамтран 2023 оны 10 дугаар сарын 23-аас 30-ны өдрүүдэд Говьсүмбэр аймгийн хяналт нэвтрэлтийн постод орон нутгийн замын хөдөлгөөнд оролцож буй жолооч тээврийн хэрэгслийн 2,549,000 төгрөг бүхий авто замын хураамж болон торгууль төлбөрийг ГЭРЭГЭ пос машин ашиглан төлүүлж ажилласан.

2023 оны 10 дугаар сарын 25-аас 11 дүгээр сарын 25-ны өдрүүдэд Говьсүмбэр аймаг дахь Төрийн цахим үйлчилгээний хэлтэс Facebook page хуудсанд шинээр 15 пост мэдээлэл, бусад байгууллагын 75 пост мэдээллийг хуваалцаж нийт 5495 иргэнд хүрч хандалт авсан.

www.Huduu.mn сайтад 9 цэсэнд нийт 343 төрлийн мэдээлэл оруулсан өдөр тутам аймгийн хэмжээнд болсон шинэ мэдээнүүд болон ажлын байр, арга хэмжээ гэх мэдээллүүдийг оруулан ажилласан. 11 сарын байдлаар 21 аймгаас хамгийн их хандалттай буюу 1084 хүний хандалттай байна.

Шивээговь сумын Засаг даргын Тамгын газар:

Аймгийн Засаг даргаас өгсөн үүрэг даалгаврын дагуу суманд орон нутгийн шилжүүлэггүй хөдөлмөр эрхэлж буй иргэд, албан хаагчдын судалгааг гаргаж ажилласаны үр дүнд нийт 128 иргэн шилжилт хөдөлгөөний бүртгэлийг хийлгэж орон нутгийн харьяат болсон байна.

Нийтийн эзэмшлийн гудамж талбайн тохижилтыг сайжруулж, гэрэлтүүлгийн тоог нэмэгдүүлэх ажлын хүрээнд сумын Засаг даргын 2023 оны 09 дүгээр сарын 26-ны А/143 тоот захирамжаар “Үнэлгээний хороо” байгуулагдаж, 2023 оны 11 дүгээр сарын 06-ны өдөр тендерийг tender.gov.mn-д зарласан.

“Боловсролын байгууллагад ширээ, сандал ком, компьютер нийлүүлэх тухай” 2023 оны 09 дүгээр сарын 18-ны өдөр зарлагдсан тендерийн гүйцэтгэгч компани шалгарч, 2023 оны 11 дүгээр сарын 10-ны өдөр тус компанитай гэрээг хийгээд байна.

Орон нутгийн 15 нэр төрлийн татварын орлого бүрдүүлэхээс 11 дүгээр сарын байдлаар 11 төрлийн татварын орлого бүрдээд байна. ОН-ын татварын орлого гүйцэтгэлээр 1,797,981,800 төгрөг бүрдсэн байна.

Сумын ИТХ-ын 2021 оны 11-р сарын 2-ны өдрийн 114-р тогтоолоор гаргасан “Малжуулах журам”-ын дагуу ажлын хэсэг байгуулагдаж, тус ажлын хэсэг 2023 оны 10 дугаар сарын 17, 23-ны өдрүүдэд хуралдаж, малжуулах төсөлд ирүүлсэн материалуудтай танилцан, эцсийн байдлаар 5 өрхийг сонгон шалгаруулж, 296 мал олгохоор шийдвэрлэв.

2023 оны 11 дүгээр сарын 17-ны өдөр 2 дугаар багийн Иргэдийн нийтийн хурлаар малчдын өвөлжөө хаваржааны газрын танилцуулгыг хийж, өвөлжөө хаваржааны газрын хүсэлт ирүүлсэн 7 малчин өрхийн саналыг хуралд оролцсон иргэдээр дэмжүүлэн шийдвэрлэв.

Сүмбэр сумын Засаг даргын Тамгын газар:

Холбогдох хууль тогтоомжийн хүрээнд төрийн үйлчилгээг 210 иргэнд хүргэсэн бөгөөд оршин суугаа хаягийн тодорхойлолтыг 158 иргэнд олгож, бусад үйлчилгээгээр 52 иргэнд үйлчилсэн. Сүмбэр сумын 1 дүгээр багийн 118 дугаар байрны подвалыг цэвэрлүүлж, нэгдсэн эмнэлэгтэй хамтран ариутгал халдваргүйжүүлэлт, хортон шавьж устгалын ажлыг хийсэн.

2023 оны 10 дугаар сарын 19-ний өдөр Сүмбэр сумын “МӨНХ” багийн Иргэдийн нийтийн ээлжит хурлыг зохион байгуулан хуралдаанаар “Монгол улсын засгийн газрын 2050, шинэ сэргэлтийн бодлого”-ын хүрээнд Багануур, Чойр 220, 110, 35 дэд станцын агаарын шугамын өргөтгөлийн ажил болон 13 иргэний өвөлжөө, хаваржааны газрыг хэлэлцэж шийдвэрлэсэн.

Санхүүгийн албаны чиглэлээр: 2023 оны 10 дугаар сарын 31-ний байдлаар орон нутгийн орлогын төлөвлөгөө 4051,6 сая төгрөг, гүйцэтгэл 5558,3 сая төгрөг буюу 137,2 хувьтай, орон нутгийн авлага 6860,0 мянган төгрөг, өглөг 4316,8 мянган төгрөг байна.

Статистикийн тухай хууль, статистикийн хэрэглээ, ач холбогдол, жендерийн статистик, орон нутгийн статистикийн мэдээллийн танилцуулга, төрийн байгууллагуудын хамтын ажиллагаа, статистикийн мэдээний уялдаа холбоог хангах, ХАӨМСангийн алдаа, мэдээллийн зөрүүтэй байдлыг арилгах зорилгоор Сүмбэр сумын гурван сумын статистик хариуцсан 30 албан хаагчийг хамруулан “Сумын анхан шатны статистикийн ажилтнуудын зөвлөгөөн”-ийг зохион байгуулан ажилласан.

Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн хэрэгжилтийг хангах, түүх соёлын үл хөдлөх дурсгалыг хамгаалдаг 20 иргэнтэй гэрээ байгуулан, тухайн дурсгалуудад хяналт тавих ажлыг сайжруулах талаар чиглэл өгч ажилласан. Мөн тухайн иргэдэд шатахууны урамшуулал олгосон.

Өсвөр насны хүүхдүүдийг үе тэнгийн дарамтад өртөхөөс урьдчилан сэргийлэх, хүүхдүүдийн чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх зорилгоор "Colorful day" эвэнт арга хэмжээг сумын “Хүүхдийн зөвлөл”-тэй хамтран зохион байгуулж 150 сурагчийг хамрууллаа.

Хоршоо хөгжүүлэх сан: Оны эхэнд нийт 42 зээлдэгчийн 503.8 сая төгрөгийн хугацаа хэтрэлттэй үлдэгдэл байснаас 11 дүгээр сарын 20-ны байдлаар 12 зээлдэгч 94,3 сая төгрөгийн зээлээ бүрэн төлж барагдуулан 21 зээлдэгч 48.1 сая төгрөгийн зээлийн эргэн төлөлтийг төлж нийт 142.4 сая төгрөг төвлөрүүлээд байна.

2023 оны 10 дугаар сарын 31-ний байдлаар төлөвлөгөөний дагуу 276.0 сая төгрөг төвлөрүүлэхээс 161.6 сая төгрөг төвлөрүүлж 58.5 хувийн эргэн төлөлттэй байна. Хугацаа хэтрэлттэй зээл 33 хувиар буурсан үзүүлэлттэй байна.

Төрийн албан хаагчдад зориулсан нийтийн байрны засварын ажлыг гэрээ байгуулан 12 дугаар сарын 30-ны өдөр хүлээн авахаар эхлүүлээд байна.

2023 оны Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдэх “Шинэ суурьшлын бүсэд цахилгаан татах ажил”-ын тендерийг 2023 оны 10 дугаар сарын 27-ны өдөр төрийн худалдан авах ажиллагааны цахим системээр зарласан.

Сумын орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр “Авто замын босоо тэмдэг, тэмдэглэгээ”-г нэмэгдүүлэх ажлын хүрээнд нийт шонтой болон шонгүй 72 тэмдгийг хүлээн авсан.Тус тэмдэгүүдийг шаардлагатай хэсэгт байршуулах ажил хийгдэхээр төлөвлөгдөж байна.

ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР